



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН ЯАМ**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,

Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2022.11.04 № 3/5627  
танай 2022.10.24 -ны № 2/1122-Т

Санал, зөвлөмж, мэдээллийг  
хүргүүлэх тухай

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ОРОН  
НУТГИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ДАРГА П.ЗОРИГТБААТАР ТАНАА

Танаас ирүүлсэн 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн Х/1122 дугаар албан бичигтэй танилцаад дараах санал, зөвлөмж, мэдээллийг хүргүүлж байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн шийдвэрийг төрлөөр нь гарган хүргүүлж байна. /Хавсралт 1/

Дээрх бүртгэлтэй болон бүртгүүлэхээр ирүүлж байгаа шийдвэрүүдэд дараах нийтлэг алдаа, дутагдал гарсаар байна. Үүнд:

1.Боловсруулалтын шатанд.

1.1.Тэмдэглэх хэсэгт үндэслэл болгосон хуулийн заалт буруу, хүчингүй болсон хуулийн заалт үндэслэсэн, эсхүл тусгайлан эрх олгосноос бусад хамааралгүй хууль тогтоомжийн заалтыг давхар үндэслэл болгон бичсээр байгааг анхаарах;

1.2.Тусгайлан эрх олгосон тухайн хуулийн агуулга, зорилго, хүрээнд нийцэхгүй, хуулиас давсан, эсхүл харилцааг дутуу зохицуулсан байх;

Тодруулбал, тэмдэглэх хэсэгт үндэслэл болгосон хуулийн заалтад “нутаг дэвсгэртээ тухайн жилд ашиглах байгалийн баялгийн нөөцийн хэмжээг хууль тогтоомжид заасан үндэслэл журмын дагуу тогтоох”-оор заасан байхад “... татвар хураамж”, “... ашигласны төлбөр хураамжийн хэмжээ, байршлыг” тогтоох байдлаар хуулийн агуулга, зорилго, хүрээнээс хальж, эсхүл эрх олгосон заалтад хамаарахгүй харилцааг нэмж тусгах, эсхүл өөр хуулиар зохицуулдаг төстэй харилцаанд хамаарах асуудлыг хуулбарлах байдлаар зохицуулалтыг хийгээд байна.

Түүнчлэн орон нутагт төлбөр, хураамж тогтоох шийдвэрийг гаргахдаа зөвхөн хуульд заасан хүрээ, хязгаарын дотор тусгайлан эрх олгогдсон тохиолдолд гаргахыг анхаарах. Өөрөөр хэлбэл Татварын ерөнхий хууль болон бусад хуульд заасан тохиолдолд төлбөр, хураамж тогтоох.

1.3.Хуулиар хориглоогүй асуудлаар хориглосон зохицуулалт тогтоохгүй байх гэж заасан байхад журамдаа “Хориглох зүйлс” гэсэн бие даасан бүлэг, зүйл

1516159 2

гарган түүндээ хуулиар хориглосон асуудлуудыг давхардуулан жагсаах, эсхүл хуулиар хориглоогүй асуудлыг шинээр зохицуулалт бий болгон хориглосон зохицуулалт тусгадаг байдлыг анхаарах;

1.4.Хуулиар тусгайлан эрх олгогдсоны дагуу тодорхой асуудлыг зохицуулсан журам батлахдаа нэр томъёо тайлбарласан заалт тусгахгүй байх;

Тодруулбал, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-д “Хуулийн нэр томъёоны утга агуулгыг хуулиас доогуур түвшний актаар тайлбарлаж, тодорхойлолт хийж болохгүй.” гэж заасныг баримталж ажиллах.

1.5.Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2-т “Захиргааны хэм хэмжээний актыг зөвхөн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд”-д нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдүүлнэ.” гэж заасан тул хугацааг хуулийн зохицуулалттай нийцүүлэх бөгөөд баталсан өдрөөс захиргааны хэм хэмжээний актыг дагаж мөрдөх хугацаа тогтоохгүй байх;

1.6.Захиргааны ерөнхий хуульд заасан тавигдах шаардлагыг хангахгүй тохиолдолд Хууль зүй, дотоод хэргийн сайдаас уг зөрчлийг арилгуулахаар хүргүүлсэн дүгнэлтийн хариуг хуульд заасан хугацаанд ирүүлж байх;

1.7.Захиргааны ерөнхий хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.1-д "хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага дангаар баталсан бол захиргааны хэм хэмжээний актыг гурван хувь /албан ёсны эх хувь, түүний баталгаажуулсан хуулбар хоёр хувь/...." гэж заасан бүрдлийн тухайд баталгаажуулсан хуулбар хоёр хувь гэдгийг байгууллагын эрх бүхий этгээд зохих журмын дагуу "хуулбар үнэн" тэмдэг дарж, гарын үсэг зурсан хувийг ирүүлэх ёстой байдаг. Гэтэл эх хувиа хоёр хувилж баталгаажуулалт хийгээгүй, эсхүл ганцхан эх хувь байхаас гадна цахим хувь хоосон, эсхүл өөр материал хуулсан, эсхүл зөвхөн шийдвэрийг, эсхүл хавсралтыг хуулбарласан байх зэргээр шаардлага хангахгүй, түүнчлэн нөлөөллийн шинжилгээ, хэлэлцүүлгийн мэдээлэл байхгүй бүрдэл дутуу материал ирүүлдэг зөрчлүүд түгээмэл байсаар байна;

1.8.Нөлөөллийн шинжилгээг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/147 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Нөлөөллийн шинжилгээ хийх аргачлал”-ын дагуу хийхгүй, зөвхөн шийдвэрийг бүртгүүлэхээр хэлбэрийн шаардлага хангах төдийд ирүүлсээр байгааг анхаарах;

Өөрөөр хэлбэл уг шийдвэр гарсны дараа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь аливаа байдлаар хөндөгдөх бүлгийг зөв тодорхойлолгүй “байхгүй” гэж бичсэн, аргачлалд заасан асуултад зохих ёсоор бүрэн гүйцэд хариулалгүй, “тийм”, эсхүл “үгүй” гэж тодорхой бус байдлаар хариулах, гол судлах ёстой асуудлыг судлаагүй, тооцоо судалгаагүй, дүн шинжилгээ хийхгүй ирүүлж байгааг засаж, эрх зүйн онол, арга зүйн хүрээнд боловсруулалтыг илүү бүтээлч байдлаар сайжруулах шаардлагатай байна.

1.9.Хэлэлцүүлгийн тухайд ямар бүлгийн хүрээнд хэлэлцүүлгийг зохион байгуулсан, хичнээн хүн оролцсон, ямар саналууд гарч, гарсан саналыг төсөлд хэрхэн тусгасан эсэх талаарх мэдээлэл байхгүй хэлбэр төдий боловсруулалтыг хийсээр байгааг анхаарах;

1.10.Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.6-д зааснаар шийдвэрийн төслийг батлахаас өмнө хууль зүйн асуудал хариуцсан нэгж, мэргэжилтнээр хянуулахгүй ирүүлж байгаагаас тогтоол болон түүний хавсралтууд хууль зүйн шаардлага хангахгүй, холбогдох хуульд нийцэхгүй, үг, үсгийн алдаатай, бүрдэл дутуу зэргээс болж дүгнэлтээр буцах тохиолдлууд гарсаар байгааг анхаарах;

1.11.Хуулиар эрх олгоогүй тохиолдолд түр журам гаргахгүй байх.

2.Бүртгэлтэй шийдвэрийн тухайд.

2.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн захиргааны хэм хэмжээний актад нэмэлт, өөрчлөлт оруулсан, хүчингүй болсонд тооцсон зэргээр өөрчлөлт оруулсан шийдвэрээ хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хянуулж бүртгүүлэхээр ирүүлдэггүй, түүгээрээ дагаж мөрддөгөөс дээрх санд холбогдох хөдөлгөөн хийгдэхгүй, орхигддог нийтлэг алдааг гаргасаар байгааг анхаарах;

Түүнчлэн захиргааны хэм хэмжээний актаа шинэчлэн батлахдаа өмнөх бүртгэлтэй шийдвэрээ хүчингүй болгосон заалт тусгадаггүй, ач холбогдолоо алдсан, эрх зүйн үйлчлэлийн хугацаа дуусгавар болсон шийдвэрээ хүчингүй болгож, санд хөдөлгөөн хийлгэх ажиллагааг хийж хэвшихгүй байна.

2.2.Бүртгэлтэй шийдвэрийн тэмдэглэх хэсэгт үндэслэл болгосон хууль хүчингүй болсон, журам батлах эрх олгосон байгууллага өөрчлөгдсөн тохиолдолд шийдвэрээ хуульд нийцүүлэх ажиллагааг хийхгүй байгааг анхаарах;

Тодруулбал, Газрын төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт газрын үнэлгээний зэрэглэл, бүсийн газрын төлбөр тооцох итгэлцүүрийн тоон утга, түүнийг хэрэглэх зааг хязгаарыг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоодог байсныг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батлахаар хуульд өөрчлөлт орсон. 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын баталсан нийт 216 шийдвэр байснаас өнөөдрийн байдлаар 110 шийдвэрийг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас хүчингүй болгож, санд хөдөлгөөн хийсэн. Харин 106 сум хүчингүй болгосон шийдвэрээ, 2 аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал баталсан шийдвэрээ тус тус ирүүлээгүй байх бөгөөд ээлжит хуралдаанд оруулахаар хүлээгдэж байна гэсэн хариуг тус тус ирүүлсэн байна.

Иймд цаашид төлбөр хураамж тогтоож байгаа шийдвэрийн хувьд хуульд заасан ажиллагааг бүрэн гүйцэд хийж цаг алдалгүй шийдвэрийг заавал ээлжит хурал хүлээж хугацаа алдахгүйгээр ээлжит бусаар хуралдааныг зохион байгуулж төрийн үйл ажиллагааг шуурхай, тасралтгүй явуулж хэвшүүлэх талаар анхаарч ажиллах шаардлагатай байна. /Хавсралт 2/

2.3.Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрээр салбарын санг бүрдүүлж, тэдгээр шийдвэрт жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж хэвших. Учир нь дээрх санд бүртгэлгүй шийдвэрийг

хүчингүй болгон хөдөлгөөн хийлгэхээр ирүүлж байгаа зөрчлүүд тасрахгүй гарсаар байна.

### 3.Бүртгүүлээгүй шийдвэрийн тухайд.

#### 3.1.Бүртгүүлээгүй шийдвэрийг нийтээр дагаж мөрдүүлэхгүй байх;

Өөрөөр хэлбэл захиргааны хэм хэмжээний актаа Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхгүйгээр мөрдүүлснээс үүсэх үр дагаврыг шийдвэр гаргасан захиргааны байгууллага хариуцахаар хуульчилсан болохыг анхаарах.

4.Нутгийн өөрөө удирдах байгууллагад Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн ХЭГ/2884 дүгээр албан бичгээр хүргүүлсэн зөвлөмжийн хүрээнд сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас орон нутгийн хөгжлийн сангийн журмыг баталж, бүртгүүлэхээр ирүүлж байна.

Гэтэл уг журмыг батлахдаа тэмдэглэх хэсэгт үндэслэл болгосон Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт "... Уг санг бүрдүүлэх эх үүсвэр нь төсвийн бус хөрөнгө байна." гэж заасныг анхаарахгүй, Төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэгт төсвийн харилцааг зөвхөн энэ хуулиар зохицуулах бөгөөд орон нутаг, салбарын үйл ажиллагаанд санхүүжилтийн эх үүсвэрийн хэмжээг хуульчлан тогтоох, түүнийг хуваарилах аливаа харилцаа үүнд нэгэн адил хамаарна" гэж, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4 дэх заалтад төсвийн захирагч нь "төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх" гэж тус тус заасныг зөрчиж, мөн хуулийн 23 дугаар зүйлийн 23.8, 23.9 дэх хэсэгт заасан сум, дүүргийн татварын болон татварын бус орлогод хамаарах орлогыг сангийн эх үүсвэр байхаар давхардуулан зохицуулж, хуваарилалт хийсэн байгаа зэрэг нь Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлд заасан шаардлагыг хангахгүй тул дүгнэлтээр буцаагдаж байна.

Дээрх асуудлыг тодруулахаар Сангийн яаманд хандсаны дагуу тус яамнаас ирүүлсэн хариу албан бичгийг хавсарган Хууль зүй, дотоод хэргийн сайдаас Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргад хүргүүлсэн албан бичгийг хавсралтаар дахин хүргүүлж байна.

5.Мөн Зөвшөөрлийн тухай хууль 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхтэй холбогдуулан Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 17 дахь хэсэгт "Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно." гэж заасан тул аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга, нутгийн өөрөө удирдах байгууллагаас зөвшөөрөл олгохтой холбоотой баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн журмуудыг хүчингүй болгож, сангаас хасуулах арга хэмжээг авах шаардлагатай байна.

Иймд аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас захиргааны хэм хэмжээний акт гарахдаа Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлд заасан шинжийг агуулсан тохиолдолд хуулийн 60 дугаар зүйлд заасан шаардлагад нийцүүлэн, энэ хуулийн 61, 62, 64 дүгээр зүйлд заасны дагуу боловсруулан баталж, 66 дугаар зүйлийн 66.1.1 дэх заалтад заасан баримт

бичгийн бүрдлийг гүйцэд хангасны үндсэн дээр Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд хянуулж бүртгүүлэх, бүртгэлтэй шийдвэртээ тогтмол дүн шинжилгээ хийж, Хууль зүй, дотоод хэргийн сайдаас хүргүүлсэн дүгнэлтийн дагуу шуурхай арга хэмжээ авч ажиллах, хуулиар тусгайлан эрх олгогдоогүй асуудлаар дүрэм, журам батлах, хуулиар олгогдсон эрх хэмжээгээ хэтрүүлэх болон нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрээ хянуулж, бүртгүүлэхгүйгээр дагаж мөрдүүлэхгүй байх, шийдвэрийг баталснаас хойш ажлын 5 өдрийн дотор хянуулж, бүртгүүлэх хугацааг баримталж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулж, бүртгүүлсэн шийдвэрүүдээр салбарын сан байгуулж, иргэдэд үйлчлэх үүргээ биелүүлж ажиллах талаарх санал, зөвлөмж, мэдээллийг үүргээр хүргүүлж байгааг хүлээн авч танилцана уу.

Хавсралт-15 хуудастай.

1.Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй аймаг, нийслэл сумдын ИТХ-аас баталсан шийдвэрийг төрлөөр нь гаргасан жагсаалт-2 хуудас,

2.Хуулиар эрх олгосон байгууллага өөрчлөгдсөнтэй холбогдуулан улсын нэгдсэн санд хөдөлгөөн хийгдэх шаардлагатай шийдвэрийн жагсаалт-7 хуудас,

3.Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн ХЭГ/2884 дүгээр албан бичиг-3 хуудас,

4.Хууль зүй, дотоод хэргийн яамны 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 1/2422 дугаар албан бичиг -1 хуудас,

5.Сангийн яамны 2022 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 03/4390 дугаар албан бичиг-1 хуудас,

6.Хууль зүй, дотоод хэргийн яамны 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 1/3862 дугаар албан бичиг -1 хуудас.

ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА



П.САЙНЗОРИГ



Д/д	Нийслэл, аймаг /сумд/	Газрын үнэлгээний бүсчлэл, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай	Малын тоо толгойн албан татварын хэмжээг тогтоох тухай	Хог хаягдлын хураамжийн хэмжээг тогтоох тухай	Орон нутгийг тусгай хамгаалалтад авах тухай	Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам	Орон нутгийн чанартай автозам, төлбөрийн хэмжээг батлах тухай	Сотгууруулах үндэс хуудалдаа, тусгай зөвшөөрөл олгох	Бичил хуудалдаа, ажил үйлчилгээний орлогын албан татварын хувь хэмжээг тогтоох тухай	Байгалийн ургамал ашигласны төлбөрийн хэмжээг тогтоох тухай	Үл хөдлөх хөрөнгийн албан татварын хувь хэмжээг тогтоох	Хилийн зааг, хамгаалалтын дэглэм тогтоох /түүх, соёл, дурсгалт зүйлийн жасгалт батлах/	Үлсын тэмдэглэлийн хураамжийн хэмжээг тогтоох тухай	Орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг бусдад түрээслэх тухай	Гадаа зар сурталчилгааны байгууламж байрлуулгахад дараж мөрдөх журам төлбөрийн хэмжээг батлах	Тээврийн хэрэгсэл түр саатуулах байрны ажиглах журам	Нийслэлийн нутаг дэвсгэрт хуудалдаа, үйлчилгээ эрхлэх нийтлэг журам	Автозэврийн болон татварын хэмжээг тогтоох тухай	Эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоох	Утаат тамхи татах зөвшөөрдөг цэгийн	Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээж ашиглах устгах булшлах	Бүртгэсэн шийдвэрийн тоо
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19		
10	Дорнод	8	13	6		2			1	1	1					1						31
11	Дундговь	6	15	12				1		1										1		37
12	Завхан	16	23	11	1	3		1						1		1				1		58
13	Орхон	1	2	1				1	1		1											7
14	Өвөрхангай	1	19	18	6	2	2	1	2	2	2	1	2	2	1	1		1		1		64
15	Өмнөговь	12	15	5			1	1	1		1		1							1		38
16	Сүхбаатар	1	14	6		3			2											1		27
17	Сэлэнгэ	16	17	5					1	1	1					1		1				43
18	Увс	17	19	5		10		1						1		1				1		55
19	Төв	10	27	20		9	1	1	1		1		1					1				72
20	Ховд	1	17	10	1	2		1	1			1										34
21	Хэнтий	1	18	17	2	5	1	1	1	1	1	1	2			2		1		1		55
22	Хөвсгөл	8	21	6	1	3	1		1		1	1	1					1				46
	<b>Нийт</b>	<b>128</b>	<b>329</b>	<b>190</b>	<b>14</b>	<b>71</b>	<b>12</b>	<b>15</b>	<b>18</b>	<b>7</b>	<b>15</b>	<b>4</b>	<b>11</b>	<b>9</b>	<b>3</b>	<b>10</b>	<b>1</b>	<b>7</b>	<b>2</b>	<b>11</b>	<b>857</b>	